

ЯПОНЫ МЭЙЖИГИЙН ҮЕИЙН ГАДААД БОДЛОГО

П.НАРАНБАЯР

Олон улс судлаач, доктор

Товч агуулга: Энэхүү өгүүлэлд Японы Мэйжигийн үеийн гадаад бодлогын товч түүхийг бичихийг зорив.

Түлхүүр үгс: Мэйжи, Солонгосын хойг, тэгш бус гэрээ, Тяньжиний гэрээ, Портсмутын гэрээ

1. Мэйжигийн үеийн Японыг судалсан байдал

Зүүн Азийн эх газарт идэвхтэй бодлого явуулах болсон ХХ зууны эхэн үеийн япончууд Монголыг угсаатан зүй, түүх, ахуй соёл, уран зохиол гэх мэт олон талаас нь судлах болов. Күрода Киётака 1886 онд эдүгээгийн Сэлэнгэ аймгийн Алтанбулаг суманд ирж, тухайн үеийн цайны замын томоохон зангилаа байсан Маймай суурингийн тухай болон гаалийн мэдээг бичиж үлдээсэн, Японы Гадаад хэргийн яамны захиалгаар 1905, 1906 онд Улиастай, Ховд орчмоор аялан явж, Монгол дахь Оросын нөлөөний талаар социологи мэдээ голлон цуглуулсан Күсамаса Кичи нарын гурван япон хүний цуглуулсан мэдээлэл, Японы нэрт угсаатан зүйч Тории Рюүзоогийн 1908 онд Халх гол, Буйр нуур, Бурхант орчимд хийсэн судалгааны талаар судлаач Боржигин Хүсэл дэлгэрэнгүй мэдээлжээ. Мөн Японы түүхэнд нэрээ үлдээсэн Оотанигийн экспедиц (大谷探検隊) 1908 онд Монголоор аялж, шашин соёлын олон мэдээг цуглуулсан байна. “Монголын нууц товчоо”-г Нака Мичиё 1908 онд япон хэлнээ орчуулж, “Чингис хааны магад хууль” (成吉思汗実録) нэртэйгээр хэвлүүлсэн нь дэлхийд ууганд тооцогдох орчуулгын нэг юм. Т.Мөнхцэцэг “Япон дахь Монголын түүхийн судалгаа” хэмээх нэг сэдэвт бүтээлдээ 1900-2005 он хүртэлх буюу зуу гаруй жилийн хугацаанд Монголыг судалсан япон судлаачдын бүтээлийг тухайлан авч үзжээ. Мөн хоёр орны дипломат харилцааны түүхийн тухайд судлаач Ц.Батбаяр, Б.Сэржав нарын бүтээл бий. Японы бүрэн түүхийг үечлэн бичсэн “Японы түүх” хэмээх сурах бичгийг доктор Т.Мөнхцэцэг туурвин олны хүртээл болгосон байна.

Соён гэгээрүүлэгч Жамсрангийн Цэвээн (1881-1940) 1913 оны 9 дүгээр сарын 14-ний “Шинэ толь” сэтгүүлийн 4 дүгээр дэвтэрт “Япон улсын учир”

хэмээх нийтлэлдээ, “Япон улс эрт цагаас янагш эрдэмтэй боловсон улс боловч саяхан болтол Европын эрдмийг хэрэглэлгүй байтал өдгөө тавь жаран жилийн өмнө Европын улс лугаа барилдлага хийж, нэгтэйгүүр оюун хурц олон залуусыг олон улсад зарж, зүйл бүрийн эрдмийг сургаад бас нэгтэйгүүр гадаад улсаас эрдэмтдийг залж авчран, олон зүйлийн их бага сургууль байгуулж, тэдгээр багш нараар багшлуулан, одоо цагийн эрдмийн туйлд хүрч, их хүчирхэг улсуудын тоонд багтжээ” гэжээ. Энэ бол монголчууд Мэйжигийн шинэчлэлийн бодлогыг шинжлэн нягталж байсныг харуулсан хэрэг гэж түүхчид үнэлжээ.

1924 онд Ардын засгийн газар анхны үндсэн хуулийг батлахдаа гадаад улс орнуудын үндсэн хуулийг орчуулах ажлын хүрээнд Мэйжигийн үндсэн хуулийг орчуулсан мэдээ бий. “Анхны Үндсэн хуулийг боловсруулах ажлын хэсэг байгуулах шийдвэрийг Ардын Засгийн газар, Монгол Ардын Намаас 1922 оны 5 дугаар сарын 19-нд гаргаж, тус ажлын хэсгийн даргаар Шүүх яамны сайд, хурц гүн Магсаржавыг томилжээ...Уг ажлын хэсэг Зөвлөлт Орос Улс, АНУ, Япон, Бельги зэрэг улс орнуудын Үндсэн хуулиудыг орчуулж, судалж байсныг хөрөнгөтөн орнуудын Үндсэн хуулиудыг хуулах нь гэсэн үндэслэлээр 1922 оны 12 дугаар сард татан буулгажээ.”

2. Мэйжигийн гадаад бодлого

2.1. Ивакүрагийн айлчлал

1871 оны 11 дүгээр сард Мэйжигийн төр засаг Гадаад хэргийн сайд Ивакүра Томомигийн ахалсан 46 хүнтэй төлөөлөгчдийг Америк, Европын орнуудад илгээв. Тэд Бакүфүгийн төгсгөл үед их гүрнүүдтэй байгуулсан тэгш бус гэрээнүүдийг өөрчлөх хэлэлцээ хийх, өрнөдийн хөгжлийг судлах гэсэн зорилго тавьжээ. Тэгш бус гэрээг өөрчлөх тэдний хүсэлтийг их гүрнүүд хүлээж авсангүй. Тиймээс төлөөлөгчид хүчирхэг гүрний хөгжлийг судлахад анхаарлаа чиглүүлэв. 1873 оны 9 дүгээр сард айлчлалын бүрэлдэхүүн буцаж ирсний дараа 1878 онд Күнэёмэ Такэаки “Америк Европоор аялсан үнэн тэмдэглэл” хэмээх аян замын тэмдэглэлийг 100 дэвтрээр хэвлүүлэн, олон нийтэд өрнө дахины хөгжлийн бодит байдлыг хүргэжээ.

“Европт өөрийн тусгаар тогтнолоо бататгаж буй бага буурай улс болбоос идэр хурц цэрэгтэй байна. Бельги Дани нь үүний жишээ мөн. Бельгичүүд эрүүл чийрэг, дайтахдаа гаргуун. Их гүрнүүдийн дунд оршиж, өөрийн хүчээр улсаа батлан хамгаалахыг гол болгожээ. Дайны цагт бусад улсууд хоорондоо алалдахад төвийг сахих эрхийг хангахуйд дөрвөн зүгт хүрэх хурц цэргийн хүч үгүй бол хэрхэн төвийг сахиж чадах билээ...Үүний тулд улсын дотор боловсролыг дэлгэрүүлж улсын эрхийг бүрэн бататгаж

байна" гээд бага сургуулийн боловсролын системийг нарийн судалж, бага сургуулийн түүхийн хичээлийн ач холбогдлыг өндөр үнэлэн, "...Өвөг дээдсийн эр зоригийг өвлөн, үеийн үед тэднийгээ магтан дуулах сэтгэлийг уураг тархинд нь шингээж, эх оронч сэтгэлийг бадраахад орших бөгөөд энэ нь дорно дахины түүхийн үзлээс өөр" гэжээ.

Тухайн үеийн Японы удирдагч нар олон улсын дэг журмыг зохицуулдаг олон улсын эрх зүйн хүчинд ямар нэг хэмжээнд итгэж байсан ч 1873 оны 3 дугаар сарын 15-нд Германы Ерөнхий сайд "төмөр" Бисмарк, нэрт жанжин Молтке нартай уулзсан нь хүчтэй нөлөөлжээ. Бисмарк Оокүбо Тошимич (1830-1878) нэгдсэн Германыг байгуулахад амссан бэрхшээлийг ярьж, хүчтэй нь хүчгүйгээ барьдаг Европын олон улсын харилцаанд бага буурай орнууд олон улсын хууль, дүрмийг сахихыг хичээдэг бол их гүрнүүд өөрийн эрх ашигт нийцсэн үед чандлан сахиж, нийцээгүй үед цэргийн сүр хүчээр уландаа гишгэдэг гэж ний нуугүй зөвлөжээ. "Бисмарк, Молтке нарын их багштай учран золгосон нь туйлын завшаан болов" гэж Оокүбо тэмдэглэсэн байдаг.

Ивакүрагийн төлөөлөгчдийн ажиглалт судалгаа Мэйжигийн төрийн бодлогод хүчтэй нөлөөлөв. Аяллаас харьж ирээд Мэйжигийн төрийг удирдсан Оокүбогийн боловсруулсан бодлого, номлолд дээрх үзэл санаа тусгалаа олсон хэрэг. Оокүбо гадаадын аяллаас буцаж ирээд Ивакүра, Итоо нартай хамтран, Солонгосыг дайлах Сайгоо Такамори нарын саналыг няцаан, тэднийг засгийн эрхээс зайлуулж, Мэйжигийн төр улсыг нэгэн зүгт чиглүүлсэн юм. Энэ нь "Үйлдвэрлэлийг хөгжүүлэх"(殖産興業), "Баян улс хүчирхэг цэрэг" (富国強兵) гэсэн бодлого байв.

2.2. Тэгш бус гэрээг шинэчилсэн нь

Японы үе үеийн Гадаад хэргийн сайд нарын тэгш бус гэрээг шинэчлэх гэсэн хэлэлцээ нь, тусгаар тогтносон улсын хувьд импортын бараанд гаалийн татварын хувь хэмжээг тогтоох эрхээ (гаалийн татвар оноох эрх) олж авах, нутаг дэвсгэртээ гарсан гадаадын иргэний хэргийг Японы хуулиар шийдвэрлэх (шүүх эрх) гэсэн хоёр үндсэн асуудалд төвлөрч байлаа. Хэлэлцээ хийх арга барилын тухайд, асуудлуудыг нэг дор хамтад нь шийдэх, эсвэл, цувруулан шийдэх, мөн Японы зүгээс хамаарах улстай дангаар хэлэлцэж шийдэх, эсвэл их гүрнүүдтэй олон талт хэлэлцээ хөтлөн явуулж нэг дор шийдэх зэргээр олон янзаар оролдсон ч үр дүнд амар хялбар хүрсэнгүй.

1875 онд Гадаад хэргийн сайд Тэрашима Мүнэнори (1832-1893) их гүрнүүдтэй хэлэлцээг эхлүүлэв. Тэрбээр хоёр талт хэлэлцээний аргыг сонгож, Америктай хэлэлцсээр 1878 оны 7 дугаар сард харьцангуй тэгш эрх бүхий заалттай "Япон Америкийн худалдааны гэрээ"-г байгуулав. Гэвч

уг гэрээг хэрэгжүүлэх нөхцөл болгон бусад улстай ч үүнтэй адил гэрээ байгуулсан байх ёстой гэсэн заалт оруулснаар хэрэг дээрээ хэрэгжээгүй юм.

1879 оны 9 дүгээр сард Иноүэ Каорү (井上馨 1836-1915) Гадаад хэргийн сайдаар томилогдон дараагийн найман жилд тэгш бус гэрээг өөрчлөх буухиаг үргэлжлүүллээ. Иноүэ хэлэлцээг амжилттай явуулахын тулд өрнөдийн соёлыг дуурайж, нэвтрүүлэхээр чармайв. Тэрбээр, Японд суугаа гадаадын албаны ажилтнууд, өндөр дээд тушаалтан, язгууртнуудад зориулсан барууны маягийн бүжигт наадам зохион байгуулдаг Рокүмэйкан хэмээх европ хэв шинжийн хоёр давхар тоосгон барилгыг Токиогийн төвд бариулав. Европын соёлыг хэтрүүлэн үнэлж, латин үсэгт шилжих, христийн шашныг шүтэх үзэл бодол, хандлага дэлгэрсэн нь Рокүмэйканы үе хэмээгдэх энэ зурвас үе юм.

Иноүэ өмнөх хэлэлцээнээс сургамж авч, гааль, шүүхийн эрхийг хамтад нь олон талт хэлэлцээгээр хэсэгчлэн сэргээх зорилт тавив. Шүүх, гаалийн эрхийг хэсэгчлэн олгосон тохиолдолд гадаадын иргэнд газар нутагтаа зорчих эрхийг хязгаартай нээхээр шийдвэрлэв. Энэ бол Иноүэгийн хэлэлцээний гол хөзөр байв. "Иноүэ Каорү Японы газар нутгийг гадаадынханд нээхээ мэдэгдсэнээсээ хойш хурлын санаачилгыг гартаа авсан" гэж түүхч Сакамото Такао үнэлжээ. Англи, Германы тал Япон бүх газар нутгаа гадаадын иргэдэд нээж өгөх, Японы хуулийг боловсронгуй болгосноо талуудад тайлагнах, консулын шүүх эрхийг Токио, Ёкохама зэрэг гол хотуудаар хязгаарлаж, бусад газарт гадаадын иргэнтэй холбоотой гомдлыг Японы шүүхэд гадаад шүүгчээр оруулж шүүлгэх санал бүхий хамтарсан төслийг ирүүлэв. Үүнийг Японы тал хүлээн авчээ.

Гэвч Японы Засгийн газрын хуулийн зөвлөх франц эрдэмтэн Бойссонад 1887 оны зун гэрээний төслийг хурцаар шүүмжлэв. Гадаад иргэнийг Японы шүүхэд шүүгчээр томилох нь консулын шүүх эрхээс ч илүү хортой, Япон улс батлан гаргах хуулиа их гүрнүүдэд нэг бүрчлэн "тайлагнах" нь улс орны сувернитет эрхийг зөрчсөн ноцтой асуудал гэж сануулжээ. Бойссонадогийн энэхүү санал олон нийтэд тарж, сөрөг хүчин болон сонинууд шинэ гэрээг эсэргүүцэв. Иноүэгийн гэрээний төслийг Засгийн газрын гишүүд, Хууль зүйн яам, Гэнроо буюу Эзэн хааны дэргэдэх Ахмадын зөвлөл бас дэмжсэнгүй. Иноүэ 1887 оны 9 дүгээр сард Гадаад хэргийн сайдын албан тушаалаасаа огцорчээ. Иноүэгийн тэгш бус гэрээг шинэчлэх гэсэн найман жилийн оролдлого ийнхүү бүтэлгүйтэв.

Түүхч Асүкай Масамичи "Мэйжигийн Засгийн газрын байр суурь их гүрнүүдийн өмнө дорой байв. Окинава, Солонгост ширүүн дориун ханддаг хэрнээ их гүрнүүдэд болохоор ар араасаа буулт хийж байсан нь Засгийн газрын зөвлөх мэргэжилтэн Бойссонадог хүртэл улс орны сувернитет эрхэд аюултай гэж дуугарахад хүргэв" гэжээ.

1888 оны 2 дугаар сард Оокүма Шигэнобү (1838-1922) Гадаад хэргийн сайдын албанд томилогдов. Оокүма олон талт хэлэлцээний аргыг өөрчлөн хоёр талын хүрээнд хэлэлцэх, үндэсний таатай нөхцөлийн заалтад тайлбар хийж, нэг улсад зөвшөөрсөн заалт бусад улсын хувьд шууд хэрэглэгддэгийг өөрчлөхийг хүсжээ. Урьд нь гаалийн эрх тогтоосон худалдааны гэрээ, консулын шүүх эрхийг тусгасан гэрээ гэж тусдаа байгуулахаар зүтгэж байсныг хамтатган, найрамдалт харилцааны гэрээ болгох чиглэлийг боловсруулав. Түүний зэрэгцээ, Оокүма Иноүэгийн гадаадынхныг аргадсан аргаас өөр арга хэрэглэв. Эдүгээгийн гэрээг хатуу мөрдөж, газар нутаг заагдан суурьших нь гадаадын иргэдэд үнэн хэрэгтээ бэрхшээлтэй гэдгийг ойлгуулахыг хичээжээ. Хоёр талын хэлэлцээ, үндэсний таатай нөхцөлд тайлбар хийсэн нь Японд хандсан их гүрнүүдийн байр суурь ялгаатай болсон цаг үеийг мэдэрсэн шийдвэр байв. 1890 оны 2 дугаар сард Америктай, 6 дугаар сард Германтай шинэ гэрээ байгуулав. Гэтэл шинэ гэрээний төсөлд гадаадын шүүгчийг Японы Дээд шүүхэд 12 жилээр томилох болсон тухай мэдээ "Лондон таймс" сонинд хэвлэгдсэнээр Японы хэвлэл мэдээлэл хүчтэй эсэргүүцжээ. Мөн дөнгөж тунхаглаад байсан Мэйжигийн Үндсэн хуулийн хүрээнд гадаадын иргэнийг шүүгчээр томилох нь Үндсэн хуулийг зөрчсөн хэрэг байв. Оокүма хэлэлцээг үргэлжлүүлсэн ч Күродагийн засгийн газар огцорч, хэлэлцээ мухардав.

Япон улс одоо Зүүн Азийн хэмжээний их гүрэн болж бойжсоор байлаа. Тэд орчин үеийн үндсэн хуульт хаант засаг, эдийн засаг, боловсролын тогтолцоотой, цэргийн хувьд хүчирхэгжин өндийжээ. Дипломат хэлэлцээнд улс орны эдийн засаг, цэргийн хүч чадал нөлөө чухал үүрэгтэй нь ойлгомжтой. Гадаад хэргийн сайд Мүцү Мүнэмицү гэрээний асуудлыг дэс дараалан шийдвэрлэв. 1894 оны 7 дугаар сард Чин улстай дайтахаас өмнө Англитай байгуулсан "Япон Английн худалдаа, далайн аялал"-ын гэрээ консулын шүүх эрхийг хүчингүй болгов. Үүний дараагаар бусад гүрнүүд тус тусын гэрээг шинэчилжээ. Тухайн үед Алс дорнодод Англи, Оросын зөрчилдөөн гүнзгийрч, Английн хувьд Японы шаардлага хэрэгцээ өссөн нь үүнд нөлөөлсөн байна.

Гадаад хэргийн сайд Комүра Жютароогийн (1855-1911) үе буюу 1911 онд Англи, Америктай байгуулсан худалдаа, далайн аяллын гэрээг дахин шинэчилж, гаалийн татвар тогтоох эрхээ олж авчээ. Мэйжигийн удирдагч нар ийнхүү 40 гаруй жилийн турш олон улсын эрх тэгш гишүүн болохын төлөө хэлэлцээ хийж, уйгагүй тэмцэн зорилгодоо хүрчээ.

Азийн бусад орнууд их гүрнүүдээс тулган байгуулсан тэгш бус хэлэлцээрийг өөрчлөхийн тулд Японоос өөр арга барилаар тэмцжээ. "Хожмын Дундад Иргэн улс шиг тэгш бус гэрээнүүдийн шударга бус, хуульд үл нийцэх байдлыг Засгийн газар өөрөө шүүмжлэн, иргэдийнхээ

үндсэрхэг үзлийг дэврээж, гадаад орнуудын эдэлж буй давуу эрх ямбыг даруй зогсоохыг шаардах аргыг Япон хэрэглэх боломжтой байсан. Харин япончууд асуудлыг дипломат хэлэлцээний хүрээнд, тайван замаар шийдвэрлэхээр хичээснийг зохих ёсоор үнэлэх нь зүйтэй” гэж түүхч Сакамото Такао дүгнэсэн байдаг.

2.3. Солонгосын хойгийн бодлого

Мэйжигийн төр улс байгуулагдахад Зүүн Азид Чин гүрэн, түүний түшмэг хараат Солонгос улс Японтой далайгаар хил залгаж байв. Өөрийн хил хязгаартай, газар нутаг дотроо эзэн эрхээ бүрэн хэрэгжүүлж, улс орнууд хоорондоо эрх тэгш харилцахыг XVII зуунд тунхагласан Вестфалийн гэрээний зарчим тухайн үеийн Зүүн Азид үйлчилж эхлээгүй байв. Чин гүрэн дангаар Зүүн Азид ноёрхож, түүнтэй харилцсан бүх гадаад улс түшмэг хараат гэдгээ хүлээн зөвшөөрч, Чин улстай худалдаа наймаа хийсэн бол түүнийгээ Чин улсад алба барьсан гэж үзэх ёстой байв. Чин улсад ирсэн гадаадын дипломат төлөөлөгч Чин улсын хаанд бараалхахдаа есөнтөө мөргөн сөгдөх ёстой болдог байв. Тэр байтугай улс орнуудын хил хязгаар нарийн тогтоогүй, зарим улс хоёр улсад ч зэрэг харьяалагдах тохиолдол цөөнгүй байжээ. Тухайлбал, эдүгээгийн Окинавагийн аралд байсан Рюүкюүгийн вант улс Японы Сацүма хошуунд харьяалагдахын сацуу Чин улсад ч давхар харьяалагдан, худалдаагаар дамжуулан их хэмжээний баялгийг өөртөө хуримтлуулж, харьцангуй бие даасан байдлаа хадгалж байлаа.

Дээрх нөхцөл байдлын дунд Япон улс эзэн хаант нэгдсэн улсаа байгуулснаа зарлан мэдэгдэж, харилцаа тогтоохоор хөрш Солонгост хандав. Гэтэл Солонгосын тал “эзэн хаан” гэсэн үгийг зөвхөн Чин улсын хаан хэрэглэх эрхтэй гээд Мэйжигийн Засгийн газрын захидлыг хүлээн авалгүй буцаав. Мэйжигийн төр улс бүрэлдэн тогтсон энэ үед Солонгос гадаадынхныг үлдэн хөөх, хил хязгаараа хаах бодлогыг баримталж байлаа.

Мэйжигийн шинэчлэлийн гол гавьяатан Сайгоо Такамори тэргүүтэй улс төрчид Солонгосыг дайлж Японы нөлөөг бэхжүүлэх саналыг шургуу тавьжээ. Сайгоогийн нэр нөлөө самүрай давхаргын дотор өндөр байснаас гадна Мэйжи хаан түүнд онцгой итгэдэг байжээ. Гэвч нас залуу Мэйжи хаан Засгийн газрын голлох гишүүд Ивакүрагийн багт багтаж Европт айлчилсан эзгүй үеэр Сайгоогийн саналыг хүлээн авах боломжгүй гэж үзэв. “Ивакүраг хүлээ” гэсэн залуу хааны шийдвэрийг хэн ч давж зүрхэлсэнгүй. 1873 оны 9 дүгээр сард Ивакүра нар Японд буцан ирмэгцээ Солонгосыг дайлах асуудлыг шууд эсэргүүцэв. Дэлхийг харсан тэд Японы хүчин чадлыг бусадтай харьцуулсан учир Солонгост цэрэглэх цаг

болоогүй гэж үзжээ. Солонгосыг дайлахыг Сайгоогийн хамтран зүтгэгч, нэг нутгийн анд Оокүбо Тошимичи ч эрс няцааж, Засгийн газар 1873 оны 10 дугаар сард Солонгост цэрэглэхгүй гэж шийдэв. Тиймээс Сайгоо болон түүний дагалдагчид огцрох хүсэлтээ тавьж, Засгийн газраас гарлаа. Харин Оокүбо болон түүнийг дагалдагчид засгийн эрхэнд үлдэв.

Япончууд Солонгосыг шууд дайлаагүй ч Солонгосын талаарх бодлогоо сулруулсангүй. Япон улс 1875 онд болсон Канхва арлын мөргөлдөөнөөр далим болгож, хаалттай Солонгосыг хүчээр нээх гэрээ байгуулжээ. Канхвагийн гэрээгээр Солонгосыг тусгаар улс гэж хүлээн зөвшөөрсөн нь Чин улсын вассал эрхийг үгүйсгэсэн хэрэг байв. Тус гэрээнд Их Чосөн улс гэж Солонгосыг нэрлээд, гэрээний эхний зүйлд "Их Чосөн улс Япон улстай адил тэгш эрхтэй тусгаар тогтносон улс болой" гэжээ. Энэ бол Солонгосын хойгт нөлөөгөө бэхжүүлэх гэсэн Японы цэрэг, дипломатын оролдлогын үндэс болов. Солонгосыг тусгаар улс болговол Оросын Солонгост халдахыг олон улсын эрх зүйн үүднээс хаана гэсэн үг. Мөн тус гэрээгээр Япон улс Солонгостой худалдаа эрхлэх боломжтой болсны дээр тэгш бус олон заалтыг Солонгосын талд тулгажээ.

2.4. Тяньжиний гэрээ

Солонгосын дотоодод хилээ хаалттай байлгаж, эзэн улс болох Чин улстай харилцаагаа үргэлжлүүлэх хүсэлтэй хуучинсаг үзэлтнүүд, Чин улсаас бүрэн тусгаар тогтнож, Япон лугаа адил хөгжих гэсэн залуу түшмэдийн хоорондох тэмцэл ширүүсэв. Японд суралцсан шинэчлэгч үзэлтэй Пак Юнхё (1861-1939), Ким Окгюнь (1851-1894) зэрэг түшмэдийн зохион байгуулсан 1884 оны Солонгосын төрийн эргэлт дарагдсаны дараа Япон, Чин улс хоёр нөлөөний хүрээний улсынхаа хувь заяаг шийдэхээр хэлэлцээний ширээний ард суув. Японоос Итоо Хиробүми Чин улсын Тяньжин хотод ирж, Ли Хунжантай хэлэлцээг эхлүүлэв.

Итоо нэгдүгээрт, Чин улсын хариуцлага хүлээх ёстой этгээдүүдэд шийтгэл оноох, хоёрдугаарт, Чин улс, Япон хоёр Солонгосоос цэргээ татах шаардлагыг тавилаа. Мэдээж, нэгдүгээрхийг Чин улс хүлээн зөвшөөрөхгүй учир гол шаардлага нь хоёрдугаарх байв. Хоёр улс цэргээ татах нь Чин улсын цэргийн оролцоог Солонгосоос зайлуулж, хоёр улсын шууд зөрчлийг бууруулна. Вьетнамын асуудлаар Францтай сөргөлдөж байсан Чин улс Японыг Францтай холбоотон болохоос эмээж, буулт хийн дахин цэрэг илгээх эрхтэй гэсэн нөхцөлөөр цэргээ татах хувилбарыг дэвшүүлэв. Японы тал энэ хувилбар дээр өөрийн нөхцөлийг нэмж хүлээж авчээ. Энэ нь, Солонгост мөргөлдөөн гарсан тохиолдолд Япон, Чин хоёр улс харилцан мэдэгдсэний үндсэн дээр Солонгост цэрэг оруулж, хэрэг дууссаны дараа хоёр тал цэргээ даруй татна, гадаад цэргийн сургагчтай

Солонгосын армийг байгуулж, гадаадыг эсэргүүцсэн солонгос иргэдийн тэмцлийг даруулах тухай заалт байв. Энэхүү нэмэлт заалт нь Солонгост Японыг Чин улстай эрх тэгш байр сууринд аваачив. Мөн энэ нь хожим Японы Чин улс дайн зарлах шалтаг болов.

Хэлэлцээний явцад япончууд Францыг овжин ашигласан нь харагддаг. Тухайн үед Вьетнамын асуудлаар Чин улстай зөрчилдсөн Франц Чин улсын эсрэг холбоотон болох нууц саналыг Японд тавьсныг Итоо зориудаар Ли Хунжанд дэлгэж, хөзөр болгон ашиглажээ.

2.5. Япон-Чин улсын дайн

Солонгост Тонхаг (東学) хэмээх шашны бүлэглэлийн олныг хамарсан бослого 1894 онд дэгдэв. Энэ нь өрнө дахины нөлөөг эсэргүүцсэн хүн, буддизм, даосизмын холимог маягийн шинээр үүссэн шашин суртал байлаа. Солонгосын хаан Чин улсад хандан бослого дарах цэрэг илгээхийг хүслээ. Солонгос Чин улсаас цэрэг илгээхийг хүссэн мэдээг Гадаад хэргийн сайд Мүцү Мүнэмицү хүлээн авмагцаа дөрвөн мянган цэрэг илгээсэн ч тэднийг очиход бослого хэдийн дарагдсан байлаа. Солонгост цэргээ оруулсан боломжоо дээд зэргээр ашиглах хэрэгтэй гэж Мүцү үзэв. Мүцү Чин улсад хандан, Солонгост дотоодын шинэчлэлийг хамтран хэрэгжүүлбэ гэсэн санал тавив. Мэдээж Чин улс зөвшөөрөлгүй, цэргээ татахыг Японоос шаарджээ. Шалтаг олдлоо. Зодоонд бэлдэх сүүлийн бэлтгэл ажил бол их гүрнүүдийн байр суурийг тандах. Оросын зүгээс Чин улс, Японы хооронд зуучлах санааг цухалзуулав. Үүнийг мэдсэн Англи нөлөөгөө алдахгүйн тулд Оросоос тусдаа зуучлах санаачилга гаргалаа. Энэ нь Солонгост Япон орж ирснээр Оросын эсрэг бамбай болно гэж Англи үзэж байгаа бөгөөд цэргийн ажиллагааг цааргалахгүй гэдгээ илэрхийлсэн хэрэг байв. Мүцү ийнхүү Солонгосын хойгт Японы чөлөөтэй хөдлөх боломжийг бий болгожээ.

1894 оны 7 дугаар сард Японы тал Солонгосын Засгийн газарт Чин улстай вассалын харилцаагаа эцэслэж, Чин улсын цэргийг даруй гаргахыг шаардлаа. Түүний дараа Япон улс 7 дугаар сарын 23-нд цэргийн хүчээр Солонгост төрийн эргэлт хийв. 7 дугаар сарын 25-нд Фүдао арлын ойролцоо Япон, Чин улсын хооронд тэнгисийн цэргийн мөргөлдөөн болж, 8 дугаар сарын 1-нд хоёр улс хоорондоо албан ёсоор дайн зарлав. Дайн эхэлмэгц Япон далай, хуурай газарт илт давуу ялалт байгуулав. Японы хуурай замын цэрэг Манжуурт нэвтэрч, усан замын цэрэг Шар тэнгисийг хяналтдаа аван, Ляодун, Шаньдунгийн хойгт цэрэг буулган, Вэйхайвэйг 1895 оны 1 дүгээр сард эзэлснээр Японы ялалт тодорхой боллоо.

Зүүн Азийн хамгийн том гүрэн арлын жижиг Японд ингэж хялбархан ялагдсан нь орчин үеийн цэрэг арми, технологиос гадна иргэдийн

боловсролтой холбоотой байв. Япончууд орчин үеийн боловсролыг сургуулийн системээр эзэмшиж, улс орны хувь заяаг өөрийн хувь заяатай адилтган үзэх эх оронч үзэлтэй иргэн болон хүмүүжсэн бол Чин улс тийм биш байлаа. Японы арми 120 мянган цэрэгтэй Хятадын эх газарт цэргийн үйл ажиллагаа явуулж байхад түүнтэй байлдсан нь Ли Хунжангийн 50 мянган цэрэгтэй хувийн арми л байв. Олон сая хүнтэй Чин улсад цэрэг дайчилгаа явуулан, тулалдах байх гэж тооцож байсан ч тийм явдал болсонгүй. Чин улсад Японтой хийсэн дайныг сонирхох ч үгүй, Япон гэж улсыг дуулаа ч үгүй хүмүүс дийлэнх олонх байв.

2.6. Шимоносэкигийн хэлэлцээр

Шимоносэкигийн хэлэлцээр юуны түрүүнд Чин улсаар Солонгосын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрүүлж, тус улс дахь Чин улсын вассал эрхийг дуусгавар болгов. Ляодунгийн хойг, Тайваний арал, Дэнхугийн арлуудыг Японы эзэмшил болгов. Энэ нь Мэйжигийн Засгийн газрын хувьд дайнаар олж авсан анхны газар нутаг байлаа. Их хэмжээний дайны төлбөрийг Чин улс Японд төлөх болов. Уг төлбөр Японы дотоод хөрөнгө оруулалтад зориулагдаж, аж үйлдвэрийн хөгжилд томоохон үүрэг гүйцэтгэжээ. Их гүрнүүдтэй адил худалдааны онцгой эрхийг Японд олгов.

Мүцү Чин улсаас ахиу олз булаавал их гүрнүүд хөндлөнгөөс оролцоно гэдгийг урьдчилан мэдэж байлаа. Гэвч дайны ялалтад хөөрсөн олон нийтийн санаа бодолд нийцүүлэн, Чин улсаас ихийг салгах хэлэлцээ хийхээс өөр аргагүй гэж үзжээ. Түүний таамаглалын дагуу болж, Ляодунгийн хойг Японы эзэмшилд очих болсонд дургүйцсэн Оросын зүгээс Франц, Герман улстай нийлэн, Ляодунгийн хойгоос гарч явахыг 1895 оны 4 дүгээр сарын 23-нд Японд сануулав. Орос, Франц, Германы шаардлагын тухайд Ерөнхий сайд Итоо гурван гүрний оролцоог хэрхэхийг зөвлөлдөв.

1. Гурван гүрний шаардлагыг бүхэлд нь няцаах
2. Асуудлыг бусад их гүрнийг оролцуулан зөвлөлдөх
3. Гурван гүрний сануулгыг хүлээж авах гэсэн гурван хувилбараар хэлэлцэв.

Зөвлөгөөнд оролцогчид удаан ярилцсаны эцэст, асуудлыг өөрсдөө шийдэлгүй их гүрнүүдтэй зөвлөлдөнө гэсэн 2 дугаар хувилбарыг дэмжжээ. Үүнийг дуулсан Мүцү Ерөнхий сайдад захидал илгээн, их гүрнүүдээр асуудлыг хэлэлцүүлбэл асуудал Ляодунгийн хойгоор хязгаарлагдалгүй бусад асуудалд үсэрхийлэх аюултай тул шууд гурав дахь хувилбарыг сонгох хэрэгтэй гэжээ.

Япон гурван гүрний сануулгыг хүлээн авч, Ляодунгийн хойгийг Чин улсад буцаан өгөх тухай зарлиг гаргав. Үүнээс хойш Японы төрийн

зүтгэлтнүүд их гүрнүүдтэй дипломат ажиллагаагаа уялдуулах зарчмыг хатуу баримтлах болжээ. Энэ үйл явдлыг "Гурван гүрний оролцоо" гэж түүхэнд тэмдэглэдэг. 1896 оны 5 дугаар сард ширээнд суух II Николай хааны ёслолд оролцсон Ли Хунжан Батлан хамгаалах холбоотны нууц гэрээг Оростой байгуулав. Уг гэрээгээр Оросууд Владивосток хүртэл Чин улсын нутаг дэвсгэрээр дайруулан төмөр зам барьж, ашиглах эрх болон Японы буцаан өгсөн Ляодунгийн хойгийг 1898 оноос Орост концессоор өгч, Порт-Артур боомтоор далайд гарсан төмөр зам барих эрхийг олгожээ. Ингэснээр оросууд хөлддөггүй боомтыг олж авчээ.

Нууц гэрээний тухай тэнгисийн их гүрэн Англи мэдээд цочив. Худалдааны гол зам эх газраас далай тэнгист шилжсэн үеэс Англи хүчирхэгжин, дэлхийн их гүрэн болсон бол төмөр зам хөгжсөнөөр Орос эх газрын их гүрэн болж, Англитай мөчөөрхөж эхэлсэн хэрэг. Суларч доройтсон Чин гүрнээс их гүрнүүд чадах чинээгээрээ концесс хэлбэрээр газар нутгийг нь тасдан булааж эхэллээ. Герман Чинтаог, Франц Гуанжоугийн буланг, Англи Жюүлун, Вэйхайвэйг тус тус концессоор эзэмшиж эхлэв. Концессын энэ уралдаанд хоцорсон Америк Чин улсад улс орнууд тэгш эрхтэйгээр худалдаа эрхлэх "Нээлттэй хаалганы бодлого"-ыг зарлав. Америк Чин улсыг колоничлох байдлаар хуваахыг хүсэхгүй байв. Чин улсыг тойрсон Япон, Англи, Орос, Герман, Франц, Америкийн ашиг сонирхол тодорхой болж ирлээ. Англи, Герман Оростой шууд үзэлцэх хүсэлгүй ч, Оросын нөлөө Манжуур, цаашлаад Солонгост бэхжихийг хүсэхгүй. Оросын холбоотон Франц ч Оросын алс дорнодод түлхсэн том давшилтыг хүсэхгүй. Энэ нөхцөлд Оросын давшилтыг зогсоох хамгийн боломжтой улс бол Япон болох нь ойлгомжтой байлаа.

Чин улсад Ихэтуан буюу боксёруудын бослого гарч, гадаадын иргэдэд халдах, элчин сайдын яамдыг бүслэн дайрсан учир их гүрнүүд арми бүрдүүлэн Бээжинд оруулахад япончууд их гүрнүүдийн нэгэн гишүүн болж цэргээ оруулжээ. Чин улсыг тойрсон их гүрнүүдийн том тоглоомд Оросыг ганцаардуулж, Англи, Германтай ойртох алхмуудаа Япон хийсээр байлаа. Харин бослогыг дарахаар орж ирсэн оросууд гарч яваагүйгээр үл барам Манжуурт 160 мянган цэрэг оруулж, бэхэлсээр байв. Үүнийг мэдээж их гүрнүүд зүгээр хараад суухгүй.

2.7. Англи, Японы холбоотны гэрээ

Чин улс болон Солонгосын хойгийн асуудлаар Орос, Английн харилцаа хурцадлаа. Зүүн Азид хүчирхэгжин гарч ирсэн Япон улс Английн хувьд найдвартай түнш болно. Газар нутгаа өмнө тийш тэлэхээр идэвхтэй бодлого явуулсаар байгаа Оросыг хазаарлах нэг хүчин зүйл бол Английн хувьд Япон. Тиймээс Англи, Японы харилцаа ойртож, холбоотны гэрээ

байгуулагдах нь цаг хугацааны асуудал болов. Эзэн хааны Ахмадын зөвлөлийн гишүүн Ямагата Аритомо Англитай холбоотны гэрээ байгуулахыг дэмжиж, Англид суугаа Японы элчин сайд Катоо Такаакигаар дамжуулан идэвхтэй дипломат ажиллагаа явуулав. Англи бус Оростой учир зүйгээ олох гэсэн үзэл бодолтой нөлөө бүхий улс төрчид гэвэл Ерөнхий сайд асан Итоо Хиробүми, Гадаад харилцааны сайд асан Иноүэ Каорү нар байлаа. Англитай холбоотон болж Оросыг цохих, Оростой учраа олж, геополитикийн наймаа хийх энэ хоёр тал хоёул эвлэршгүй хүчнүүд биш байв.

Англи, Японы холбоотны гэрээ 1902 онд байгуулагдаж, хожим хоёр удаа шинэчлэгджээ. Энэхүү гэрээ Япон улсын хувьд анхны холбоотны гэрээ болно. Гэрээ нь цэргийн хамтын ажиллагааг шууд тогтоогоогүй юм. Хэрэв гэрээний аль нэг тал гуравдагч этгээдтэй дайны байдалтай болбол, нөгөө тал нь төвийг сахина. Харин гуравдагч улс дайны байдалтай байгаа гэрээний талд дайрвал, гэрээний төвийг сахисан тал дайнд оролцох үүрэгтэй гэсэн заалт л байв. Тухайн үед Орос, Франц улс холбоотны гэрээтэй байсан учир Англи, Японы холбоотны гэрээ уг дайнд Японы эсрэг Францыг оролцохоос сэргийлэх зорилготой байлаа.

Тухайн үед Зүүн Азид өндийн гарч ирсэн Японтой дэлхийн хүчирхэг гүрэн Англи гэрээ байгуулсан нь Японы байр суурийг дээшлүүлж, хүчний тоглоомд оролцогч улс болгожээ. Энэ бол Японы дипломат ажиллагааны том ялалт байлаа. Тухайн үеийн дэлхийн хамгийн хүчирхэг гүрэн Английг холбоотон болгосон Японы хувьд Оростой байлдах дипломат ажиллагааны бэлтгэл хангагдсан хэрэг.

2.8. Орос-Японы дайн

Манжуурыг Орост өгч, Солонгосыг Японд авах тохиролцоо хийж, Орос, Японы хооронд болох дайнаас зайлсхийх гэсэн Итоо Хиробүми нарын оролдлого талаар болж, дайн 1904 оны 2 дугаар сард эхлэв.

Америк, Англи улсууд дайнд зориулсан Японы Засгийн газрын бондыг худалдан авч санхүүжүүлж байлаа. Тухайн үеийн Японы төсвийн орлогыг бараг 4 дахин нугалсан дайны зардлын ихэнхийг энэхүү бондоор санхүүжүүлжээ. Олон улсын зах зээл дээр Японы Засгийн газрын бондыг борлуулж мөнгө босгох болон Орос дотор болон Хаант Орост шахагдан гадаадад дүрвэсэн орос, еврей нарын дунд явуулсан Японы тагнуулын үйл ажиллагаа идэвхжиж үр дүнд хүрч байжээ. Ленинийг Японы тагнуулууд нууцаар санхүүжүүлж, 1905 оны Цуст ням гарагийн жагсаал болсон, Оросын эзэн хаан еврейчүүд, польшуудыг хавчин шахах бодлого явуулсанд дургүйцсэн Америк болон өрнөдийн орнуудын банк санхүүд нөлөө бүхий еврейчүүд Японы бондыг худалдан авч, дайны зардлыг

гаргасан, Америкт мөнгө босгох үйл ажиллагааг Сангийн сайд байсан Такахаши Корэкиё (1854-1936) амжилттай зохион байгуулсан зэрэг нь үүний нэг хэсэг. Японы Засгийн газар дайны бондын үнэлгээг унагахгүйн тулд цэргийн томхон ажиллагааны үр дүнтэй хослуулан бондоо борлуулж байв. Японы цэргийн ажиллагаа, олон улсын нөхцөл байдал, улс төрийн үйл ажиллагаатай нарийн уялдаж, улс төрчдийн манлайлал доор явагдсан нь хожмын Дэлхийн хоёрдугаар дайны үеийнхээс эрс ялгаатай гэж судлаачид дүгнэдэг.

Бидний мэдэх самүрайн ёс зүйн талаар бичсэн “Бүшидоо” хэмээх бүтээлийг Японы сэхээтэн Нийтобэ Иназоо чухам энэ үед өрнийхөнд япончуудыг ойлгуулах, уламжлалт үзэл суртал, самүрайн соёлыг сурталчлах зорилгоор туурвижээ.

Мүгдэн, Порт-Артурт болсон хуурай замын цэргийн голлох тулалдаануудад Япон ялав. Мөн Шар тэнгист Оросын Алс дорнодын флотыг, Япон тэнгист Оросын Балтийн флотыг тус тус бут ниргэв. Японы эдгээр ялалтад Английн оруулсан хувь нэмэр нэлээд байлаа. Алс дорнодод чиглэсэн Балтийн флотыг Суэцийн сувгаар гаргахгүй, колони орнуудынхаа боомтод оруулахгүй, нүүрс түлшээр хангахгүй болгосноор тэднийг дэлхийг бараг бүтэн тойроход хүргэв. Замдаа боомтуудаас хангалт авч чадахгүй болсон Балтийн флот Алс дорнодод төлөвлөснөөсөө ихээхэн хоцорч хүрсний дээр туйлдаа хүртэл ядарч цуцсан байв. Мөн Газрын дундад тэнгисээр явах гэсэн Хар тэнгисийн флотыг Английн тал дипломат ажиллагаагаар зогсоож чадсан нь Японы ялалтад томоохон нөлөө үзүүлжээ.

Дайн эхэлсэн анхны өдрөөс Америк Япон, Английн талд оржээ. “1895 оны гурван гүрний оролцоо шиг үйл явдал давтагдвал Америкийн Засгийн газар Японы талд зогсож, хамгаалах шаардлагатай гэж үзсэн бүх арга хэмжээг авах болно” гэж Франц, Германд хандан АНУ-ын ерөнхийлөгч Т.Рузвельт мэдэгджээ.

Дээр дурдсан тулалдаануудад Япон ялалт байгуулснаар Оросыг хэсэг хугацаанд байлдах чадваргүй болгосон ч цэрэг, эдийн засгийн нөөц нимгэн улсын хувьд түр зуурын ялалт гэдэг нь ойлгомжтой. Дайн сунжирвал Сибирийн төмөр замаар шинэ хүч, нөөцийг Манжуурт татсаар байгаа их гүрэн Оросыг дийлэхгүй. Эх газрын их гүрэн Оросыг бүрэн ялахгүй гэдгээ Японы эрх баригчид маш сайн мэдэж байлаа. Тиймээс Цүшимагийн байлдаанд ялалт байгуулсны дараа япончууд дайныг зогсоох хэлэлцээг эхлүүлэхээр яаравчилж, Америкийн Ерөнхийлөгч Рузвельтэд хандан зуучлахыг хүслээ.

Азийн зах зээлд гарааны тэгш байдал үүсгэх зорилгоор “Нээлттэй хаалганы бодлого”-ыг их гүрнүүдэд уриалдаг Америк Манжуурыг Орос дангаар эзэгнэсэнд дургүй байлаа. Япон харин Оросоос Манжуурт

гарааны тэгш байдал олгохыг шаардсан нь Америкийн ашиг сонирхолд нийцэв. Японы бүрэн ялалт, эсвэл бүрэн ялагдлыг Рузвельт хүссэнгүй. Рузвельт Сенатын Гадаад хэргийн хороонд илгээсэн захидалдаа "Оросын ялагдал соёл иргэншилд хандсан цохилт болох боловч Азийн улсын хувьд Орос мөхөхийг би хүсэхгүй байна. Орос, Япон сөргөлдөж орших нь бидний хувьд хамгийн хүсүүштэй" гэжээ. Мөн шинээр хүчирхэгжсэн Япон улсад тус хүргэх нь өөрийн харьяанд оруулсан Филиппиний аюулгүй байдалд ашигтай гэж Рузвельт тооцжээ.

2.9. Портсмутын гэрээ

Америкийн Ерөнхийлөгч Рузвельтийн зуучилснаар 1905 оны 8 дугаар сарын 10-нд Портсмутадад Орос, Японы энх тайвны хэлэлцээ эхлэв. Японы төлөөлөгчдийг Гадаад хэргийн сайд Комүра Жутароо, Оросын төлөөлөгчдийг Сангийн сайд Сергей Витте (1849-1915) тэргүүлэв. Японы төлөөлөгчид нэгдүгээрт, Солонгос дахь Японы эрхийг Оросоор хүлээн зөвшөөрүүлэх, хоёрдугаарт, Ляодунгийн хойгийн концесс, Өмнөд Манжуурын төмөр замыг эзэмших эрхийг авах, гуравдугаарт, боломжтой бол дайны нөхөн төлбөрийг Оросоор гаргуулах, Сахалиныг хувааж авах гэсэн асуудлыг шийдвэрлэхээр удирдамжаа боловсруулсан байв.

Оросын төлөөлөгчид 1, 2-ыг зөвшөөрсөн боловч, 3 дээр хатуу байр суурьтай байлаа. Сахалин бол Оросын газар нутгийн бүрэн бүтэн байдалтай холбоотой, дайны төлбөрийг ялагдсан нь ялсандаа өгдөг. Гэтэл Орос энэ дайнд яагдаагүй тул 3-ыг зөвшөөрөх үндэслэлгүй гээд огт буулт хийсэнгүй. Оросын хаан "Нэг ч сөөм газар өгөхгүй, нэг ч рубль төлөхгүй" гэсэн хатуу байр суурьтай байлаа. Хэлэлцээ үр дүнгүй тарах шинжтэй болсон тул Рузвельт дайны төлбөр дээр Орост буулт хийхийг Японд санал болгожээ. Комүра энэ тал дээр чиглэл өгөхийг Засгийн газраасаа хүсэв.

Засгийн газраас хэлэлцээний гол асуудал 1, 2-ын зорилгод нэгэнт хүрсэн тул 3-ыг орхиж, найрамдлын гэрээ байгуулахыг зөвшөөрчээ. Гэтэл Орос Сахалины асуудлаар Японд буулт хийн, 50 дугаар өргөргөөс өмнөд хэсгийг Японд өгөхөд бэлэн гэсэн мэдээг тохиолдлоор авсан тул Комүра сүүлчийн хуралдаанд Засгийн газрын эцсийн хувилбарыг шууд гаргасангүй. Оросын талаас сүүлчийн хувилбараа хэлэхийг хүсэв. Витте дайны төлбөр төлөхгүй, харин Сахалины өмнөд хэсгийг Японд өгөхөд бэлэн гэв. Энэ хувилбарыг Комүра хүлээн авснаар найрамдлын гэрээ байгуулагджээ. Витте баярласандаа "Энх тайван. Япон бүх зүйл дээр буулт хийлээ" гэж өөрийн мэдэлгүй дуу алдсан гэдэг. Ийнхүү АНУ-ын ерөнхийлөгч Рузвельтын зуучилснаар Япон, Оросын энхийн хэлэлцээ байгуулагдаж дайн дуусав.

Орос, Японы дайнаар япончууд Солонгосын хойгоос Оросын

нөлөөг шахаж, Солонгост хяналтаа үе шаттай өргөжүүлэх замаа нээв. Мөн Оросоос Манжуурын төмөр замыг эзэмших эрхийг олж авснаар Манжуурыг нэвтэлсэн төмөр замын гол судсыг атгаж, нөлөөний хүрээгээ Өвөр Монгол хүргэх эхлэлийг тавьжээ.

2.10. Солонгосыг нэгтгэсэн нь

Орос, Японы дайны дүнд япончууд Солонгосын хойгт давуу эрхтэй болохоо их гүрнүүдээр бүрэн хүлээн зөвшөөрүүлжээ. 1905 оны 7 дугаар сард Кацүра Тафт нарын гэрээгээр Америк, 8 дугаар сард Англи-Японы хоёр дахь холбоотны гэрээгээр Англи, 9 дүгээр сард Портсмутын гэрээгээр Орос тус тус Японы Солонгос дахь эрхийг хүлээн зөвшөөрчээ. Үүний дараа 11 дүгээр сард Япон Солонгост дарамт үзүүлж, Япон Солонгосын хоёр дахь гэрээг байгуулан, Солонгосын гадаад бодлого, санхүүгийн эрх мэдлийг Японы томилсон захирагч мэдэхээр болов. Солонгосын хэргийг хамааран суугч захирагчаар Итоо Хиробүми томилогдов. 1907 оны 6 дугаар сард Голландын Хааг хотод болсон олон улсын энх тайвны бага хуралд Солонгосын хаан нууцаар элч илгээн, Солонгосыг япончууд дарангуйлж байгаа тухай мэдээлмэгц Японы тал хааныг ширээнээс нь зайлуулж, Япон Солонгосын гурав дахь гэрээг байгуулан, Солонгосын армийг тараан, тус улсын гадаад дотоод хэргийг бараг бүхэлд нь атгах болов. 1909 оны 10 дугаар сард Итоо Хиробүмиг Орост айлчлахаар явах замд Харбин өртөөнд Солонгосын эх оронч Ан Жюнгүн (1879-1910) буудан хороосныг ашиглан, Японы тал 1910 оны 8 дугаар сард Солонгосыг бүрмөсөн нэгтгэн авчээ.

Солонгосчуудын эсэргүүцэл эсрэгээрээ Японы талд боомиллолтоо чангаруулах боломжийг өгсөөр байсан бөгөөд их гүрнүүд ч Солонгосын асуудлыг энэ хугацаанд огт хайхарсангүй. Улс орноо шинэтгэн хөгжүүлж чадалгүй, феодализм, Күнзийн сурталдаа баригдсаар сул дорой болсон Солонгост дэмжлэг үзүүлэх олон улсын орчин нөхцөл нэгэнт байхгүй болсон байв.

Богд хаанд өргөн барьсан “Хан улсын мөхсөн түүх”-д тусгаар тогтнолоо алдсан солонгосчуудын гаслант байдлыг доорх байдлаар илэрхийлжээ.

“... манай салаа мэт харьяа Рибэн улсад нухуулан баригдав. Аяа, ван хааны ордон шинэ эзэнд оров. Бичиг цэргийн түшмэлийн дээл хувцас урьд лугаа адилгүй болов. Хэдэн түмэн хүмүүн амьтныг алах аврах хүмүүний дураар болов. Хэдэн зуун оны хүүр болон хохирохуйд хүрэв. Гаслан уйлавч гаргаж мэдүүлэх газар үгүй болов...Аяа, Хан улс нэгэнтээ мөхөв.”

“Солонгосын хойг Японы гадаад бодлогыг тодорхойлох гол хүчин зүйл байв. Японы арлуудад эрт үеэс олон үндэстэн ирсэн ч цэргийн

түрэмгийлэлд өртөөгүй юм. Япон болон Хятад, Монгол, Оросын завсарт Солонгос улс оршиж, эдгээр улсын цэргийн түрэмгийллийг хааж ирсэн хэрэг. XIV зуунд Хятадаас Араб хүрсэн эх газрын их гүрэн байгуулсан монголчууд Солонгосын хойгийг эрхшээлдээ оруулахын тулд 30 жил зарцуулсан түүхтэй. Монголчууд Японы арлуудыг байлдан дагуулахаа зогсоосон нь камиказэ хэмээх хар салхинаас болсон бус Солонгосын хойг дээрх эсэргүүцэлд хүчээ барж орхисноос билээ. Үүний эсрэг жишээ ч бий. XVI зууны төгсгөл үед Тоётоми Хидэёши их цэрэг хөдөлгөн Мин улсыг дайлах гэхэд замд нь Солонгос бас тээглэсэн байдаг юм."

Солонгосыг колоничлох нь Японы хувьд зардал ихтэй, эдийн засгийн хувьд ашиггүй байсан гэж зарим түүхчид үздэг. "Япон улс Солонгосыг нийт 35 жил колоничлохдоо улсын төсвөөс Солонгост зарцуулсан хөрөнгийг түүнээс олж байсан орлоготой харьцуулахад хамаагүй их тоо гардаг. Япон улс Солонгос, Тайвань зэрэг колониосоо эдийн засгийн ашиг олоогүй."

3. Дүгнэлт

XIX зууны дундаас XX зууны эхэн. Дэлхийн хөгжлийг өрнө дахин түүчээлж, Ази, Африк, Америкийг колоничилсон үе. Монголын эзэнт гүрний эхэн үед тогтоосон соёлын олон янз байдлыг хүлээн зөвшөөрч, өөр шашныг хүлцэх, байгальдаа ойр байж, байгальтайгаа зэрэгцэн орших үзэл бодол түүхийн тоосонд дарагдаж, христийн шашин, өрнийн шинжлэх ухааны хөгжил, Дарвины шалгарлын онол, түүнийг нийгмийн онолд ашиглаж цагаан арьстан, өрнө дахины хэл, соёлын жанжлал ноёлох болов. Энэ утгаараа колоничлолын оргил үед хилээ нээсэн Японыг тухайн үеийн их гүрнүүд нааштай хүлээж аваагүй юм. Их гүрнүүд Японы хилийг хүчээр нээлгээд дараах хоёр тэгш бус нөхцөлийг тулгажээ. Үүнд,

1. Импортын татвар оноох эрхийг Япон улс өөрөө тогтоох эрхгүй
2. Гадаадын харьяат иргэнийг шүүн таслах үйл ажиллагааг Японы хуулиар шийдэхийг зөвшөөрөхгүй.

Их гүрнүүд дээрх нөхцөлийг Японд тулгахдаа орчин үеийн эрх зүйн систем бүрэлдээгүй байгаатай холбон тайлбарлаж байв. Тиймээс Мэйжигийн төр улс Үндсэн хуулиа баталж, орчин үеийн хуулийн боловсронгуй системийг нэвтрүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэхийн сацуу тэгш бус гэрээг шинэчлэхэд 30 гаруй жил зарцуулжээ. Монгол Улс 1911 оноос 1945 он хүртэл тусгаар тогтнолоо их гүрнүүдээр хүлээн зөвшөөрүүлэх гэж 30 гаруй жил тэмцсэнийг дашрамд дурдъя.

Мэйжигийн гадаад бодлого үзэл суртлын хатуу хүлээсэнд байгаагүй гэж үзэх нь бий. "Мэйжигийн гадаад бодлого үзэл сурталд баригдаагүй прагматик шинжтэй байхад олон нийт утопи хандлагатай байж, гадаад

бодлогын асуудлаар төрийн прагматизмтай зөрчилдөж байв” гэж Японы судлаач Ириэ Акира дүгнэжээ. Тухайлбал, олон нийт тэгш бус гэрээг өөрчлөх хэлэлцээг “улсыг мөхөөнө” гэж шүүмжлэхийн сацуу Солонгос, Чин улсад зоригтой шинэчлэл явуулахыг шаардаж, европжилтийг үгүйсгэх зэргээр Засгийн газрыг үндсэрхэг атлаа хэрээсээ хэтэрсэн хатуу байр суурьтай гадаад бодлого хэрэгжүүлэхийг шаардаж байжээ.

Зүүн Азид ноёлж ирсэн хятад төвт соёл иргэншил, олон улсын уламжлалт харилцааг япончууд идэвхтэй эвдэж, орчин үеийн үндэстэн улсуудын харилцаанд оруулсан юм. “Япон хилээ нээн, Мэйжигийн шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлж “олон улсын эрх зүйн тогтолцоо”-г Азид нэвтрүүлж эхэлснээр өрнөдийн гүрнүүдийн дэмжлэгийг олж, Зүүн Азийн ертөнцийг “чөлөөлөх” хурц тэргүүн цэрэг болжээ” Нөгөөтэйгүүр, 1905 оноос хойш Мэйжигийн Япон улсын явуулсан Манжуур, Хятадын эх газар, Солонгосын хойгийн бодлого түүн дотроо 1905, 1912 онуудад Хаант Орос, Японы хооронд байгуулсан нөлөөний хүрээгээ хуваах нууц гэрээнүүд Монголын тусгаар тогтнолын тэмцэлд сөргөөр нөлөөлөөд зогсохгүй, монголчууд Ар, Өвөр болон хуваагдахад гүнзгий нөлөөлсөн юм.

Орос-Японы дайны дараа Оросыг ялсан Японоос цэрвэх “Шар арьстны аюул”-ын тухай үзэл өрнөдөд хүчээ авч, Америкт япон цагаачдыг гадуурхах нь хүчтэй болов. “Шар арьстны аюул” номлолыг Орос-Японы дайны дараагаар Германы зүгээс хүчтэй дэлгэрүүлж, Орост дэвэргэж эхэлсэн байдаг. Энэ нь цаашдаа Япон-Америк, Япон-Английн харилцааг хөндийрүүлж, Азид нэвтрэх Германы геополитикийн тоглолтод ашигтайгаар үйлчилжээ.

Японы судлаач Фүжиока Нобүкацү геополитикийн үүднээс Японы гадаад бодлогыг дараах байдлаар тайлбарлажээ.

“...Түүхээс харахад Англи-Америктай хамтарсан үедээ Япон дипломат амжилт олж, Англи, Америктай харилцаа муудсан үед алдаж байв. Дэлхийн хоёрдугаар дайнд Англи, Америктай эсрэгцсэн нь гадаад бодлогод байж болшгүй зүйл байв. Япон хүчирхэг гүрнүүдийг дайсан болгосноор ямар ч ялах найдваргүй дайн хийсэн.”

Ном зүй

1. Асүкаи Масамичи “Орчин цагийн хандлага” Кооданшя хэвлэлийн газар, 1997 飛鳥井雅道『近代の潮流』講談社現代新書 1 9 9 7
2. Батбаяр.Ц “Монгол ба Япон XX зууны эхэн хагас” УБ, 1998
3. Баттөр.Ж “Хан улс мөхсөн түүх хэмээх нэгэн эх бичиг” Улаанбаатар, 1998
4. Боржигин Хүслэн “Мэйжигийн үеийн япончуудын Гадаад Монголд явуулсан судалгаа”, Шёовагийн эмэгтэйчүүдийн их сургуулийн судалгааны тойм 845, 2011 он ボルジギンスレ『明治時代における日本人の外モンゴル調査』昭和女子大学「学苑」(845) 2011年
5. Ириэ Акира “Японы гадаад харилцаа” Чюүоо коороншя хэвлэлийн газар, 1998 (入江昭『日本の外交』中央公論社 1998)
6. Каратани Коожин “Япон сэтгэлгээг дахин задалж үзэх нь” Бүнгэйшюншюү сэтгүүл, 1992. 164-р тал. 柄谷行人『日本精神分析再考』文芸春秋 1992
7. Кита-Ока Шиничи “Японы улс төрийн түүх – гадаад бодлого, эрх мэдэл” Юүхикакү хэвлэлийн газар, 2015 (北岡伸一「日本政治史－外交と権力」有斐閣2015年)
8. Кутаков Л.Н “Россия и Япония” Москва, 1988
9. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн мэдээ, <https://conscourt.gov.mn/?p=4300>
10. Мөнхцэцэг.Т “Япон дахь Монголын түүхийн судалгаа” тэргүүн дэвтэр 2000, дэд дэвтэр 2006, Улаанбаатар.
11. Мөнхцэцэг.Т “Японы түүх”, Бэмби сан, 2010
12. Мөнхцэцэг.Т “Монгол дахь Япон судлал” Адмон, 2007
13. Сакамото Такао “Японы орчин үе 2. Мэйжигийн төр улс байгуулагдсан нь 1871-1890” Чюүоокоороншя 1999 (坂本多加雄『日本の近代2明治国家の建設 1871-1890』中央公論社1999)
14. Сүмитани Микио “Японы түүх 22 Их Японы эзэнт гүрэнд тулгарсан сорилт” Чюүо Коороншя хэвлэлийн газар, 1966 (隅田三喜男『日本の歴史22大日本帝国の試練』中央公論社1966)
15. Сэржав.Б “Монгол, Японы харилцаа XX зууны сүүл хагаст”, ШУА, 2003
16. Фүжиока Нобүкацү “Сурах бичигт заадаггүй түүх-4”, Кэйзайшинбүншя хэвлэлийн газар, 1997 (藤岡信勝『教科書が教えない歴史4』経済新聞社 1997)
17. Шига Рёотароо “Мэйжи хэмээх төр улс. Доод дэвтэр” NHK books, 1997(司馬遼太郎『明治という国家(上)』NHKブックス1997)
18. “Японы түүхийн эрэл хайгуул-22. Токүгавагийн төгсгөл үе болон Мэйжигийн шинэчлэлийн баатрууд” Кадокава шётэн хэвлэлийн газар, 1988 (『日本史探訪- 2 幕末維新の英傑たち』角川書店1988)